



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 12/06

Эрдэнэт

Г

Г


**Олон нийтийн цагдаагийн
тоог тогтоох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас **ТОГТООХ** нь:

1.Нутаг дэвсгэрийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор аймгийн хэмжээнд олон нийтийн цагдаагийн орон тоог 40 байхаар тогтоосугай.

2.Олон нийтийн цагдаагийн таних тэмдэг, хөдөлмөрийн аюулгүй байдлын тусгай хувцас, нэг бүрийн тусгай хэрэгсэл, урамшил, сургалт явуулахтай холбогдсон зардлыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжид заасны дагуу жил бүрийн төсөвт тусгаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ